

УЦУОШТӨВ-Н

БАТЛАВ

ДАРГА

2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр



ХОВД АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ ҮНЭЛЭХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1 Хүний нөөцийн бодлого нь байгууллагын ажлын байр, албан тушаалд ажилтнуудыг сонгон шалгаруулах, тохирсон ажил, албан тушаалд ажиллуулах, хөдөлмөрлөх таатай нөхцлөөр хангах, ажилтны хөдөлмөрийг зөв хуваарилан ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнд тохирсон цалин хөлс, шагнал урамшуулал олгох, хариуцлага тооцох, сургаж хөгжүүлэх, нийгмийн асуудлыг хэсэгчлэн болон бүрэн хөнгөлөлттэй байдлаар шийдвэрлэх, тогтвортой суурьшилтай ажиллуулах, цаашид байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаанд баримтлан ажиллах чиглэлийг тогтоох явдал юм.

2. Үйл ажиллагааг үнэлж, дүгнэх

Салбарын ажилчидын эрхэлж буй албан тушаалын тодорхойлолтонд нийцсэн албан тушаал бүр дээр / инженер, техникч, өртөө харуулын, усны ажиглагч гм/ нийцсэн дүгнэх журмыг гарган мөрдүүлж, даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэнэ.

2.1 Идэвх санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, хамт олноо манлайлсан албан хаагчид тухайн ажилтны сарын үндсэн цалингийн 25 хүртэл хувиар бодож үр чадварын болон бусад нэмэгдэл хөлсийг олгоно.

2.2 Үр чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, жинхэнэ ажилласан цагт ноогдох албан тушаалын цалингаас тооцож сар тутам олгоно. /Ажлын үр дүн буурсан нөхцөлд үр чадварын нэмэгдлийг олгохгүй./

2.3 Албан хаагч үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсрان буюу хослон ажилласан, түүнчлэн эзгүй байгаа албан хаагчийн үүргийг орлон гүйцэтгэвэл үндсэн цалингийн 40 хүртэл хувийн нэмэгдэл олгоно.

2.4 Албан хаагчдын Хөдөлмөрийн гэрээ, ажлын үр дүнг Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсэгт зааснаар улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгоно.

Мөнгөн урамшуулал олгоходоо Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан журмыг баримтална. Ажилтан, албан хаагчдын ажлыг дүгнэхдээ дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж хамт олны хурлаар тайланг нь хэлэлцүүлж, даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ. Үүнд:

- Ажилтны албан тушаалын төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хугацаандаа бүрэн биелэгдсэн эсэх

- Байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрт хамаарах ажлууд хугацаандаа хийгдсэн эсэх
- Олон нийт болон харьяа салбар байгууллага, аймаг орон нутгаас хэрэгжүүлж буй ажилд идэвхи санаачлагатай оролцсон эсэх
- Байгууллагад шинэ санаа, санаачилга гарган ажиллаж, нэвтрүүлсэн байдал
- Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж, нэгдсэн системд зөрчилгүй ажиллаж байгаа эсэх
- Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргүүдийг бүрэн хэрэгжүүлж буй эсэх
- Дээд газрын болон байгууллагын холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөн ажиллаж буй эсэх
- Шууд болон шууд бус удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт
- Өмнөх оноос ажлын үзүүлэлт өссөн эсэх
- Ёс зүйн сахилгагүй ажилласан эсэх

3. Шагнал урамшуулал

3.1 Байгууллага нь албан тушаалын чиг үүрэг, хөдөлмөрийн гэрээг сайн биелүүлж, идэвхи санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, хамт олноо манлайлж тодорхой үр дүнд хүрсэн шилдэг албан хаагчийг хамт олны хурлаар хэлэлцэн тодруулж, дараах байдлаар шагнаж, урамшуулна.

Үүнд: А. Салбарын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлох

Б.Харьяа яам болон газрын жуух бичигт тодорхойлох

В.Өргөмжлөл, үнэ бүхий зүйл дурсгах

Г. Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар тодорхойлох

Д. Байгууллагын оны шилдэг ажилтанаар шалгарсан тохиолдолд холбогдох хууль журмын дагуу сарын цалингийн улирлын ажлын үзүүлэлтээр 50 хүртэл, ур чадварын нэмэгдэлийг үндсэн цалингийн 25 хүртэл хувийг 3 сараар тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгох

УЦУОШТӨВИЙН ЧАНАРЫН ДОТООД ХЯНАЛТЫН КОМИСС